



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 1/231

Улаанбаатар хот

Газрын талбайн хэлбэр /солбицол/
өөрчлөх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 31 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын улаан загалмай нийгэмлэг ҮХБ нь Чингэлтэй дүүргийн 10 дугаар хороонд байрлах өөрийн эзэмшлийн 1500712278 нэгж талбарын дугаартай 2998 м.кв газрын талбайн хэмжээг 2646 м.кв болгож өөрчлүүлэх хүсэлт ирүүлснийг үндэслэн газрын талбайн хэлбэр /солбицол/-д өөрчлөлт оруулж хавсралтаар баталсугай.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2020 оны А/307 дугаар захирамжийн Монголын улаан загалмай нийгэмлэг ҮХБ-т холбогдох хэсгийг тус тус хүчингүй болгосугай.

3. Газар эзэмших эрхийн талбайн хэлбэр(солбицол) өөрчлөгдсөн хуулийн этгээдтэй газар эзэмших гэрээг зохих журмын дагуу байгуулж, гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэн авч, хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ж.Тамир)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525100660